



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/558

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 сарын 05-ны өдрийн “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолын 4 дугаар хавсралтын 2.2 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний “Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах зардлын хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/464 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Сэлэнгэ сумын төвөөс – Орхон аймаг хүртэлх хатуу хучилттай 40 км авто замын инженер геологи, зураг төсөл боловсруулах ажилд аймгийн оролцооны хөрөнгө болох 30,000,000 (Гучин сая) төгрөгийг Сэлэнгэ сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2.Аймгийн оролцооны хөрөнгийг холбогдох хууль журмын хүрээнд гэрээ байгуулан, зөвлөхийн ажлыг хүлээн авахыг Сэлэнгэ сумын Засаг дарга (Б.Ууганбаяр)-д даалгасугай.

3.Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Сэлэнгэ сумын Засаг дарга (Б.Ууганбаяр)-д тус тус даалгасугай.

4.Дээрх оролцооны хөрөнгийн санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010715